БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2022/157/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Өлгий хот 2022 он	Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn Ахлах аудитор: У.Ербол Утас: 99425121 Цахим хаяг:erbolu@ audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл 3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан 5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан 7
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан 7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....10
3. Аудитын тайлан.....11
3.1 Ерөнхий зүйл.....11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт 11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал 11
3.4 Материаллаг байдал 12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....14
3.8 Аудитын гол асуудал 14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал 14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт 15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....15
4. Аудитын илрүүлэлт 15
4.1 Залруулсан алдаа 15
4.2 Төлбөрийн акт 15
4.3 Албан шаардлага 15
4.4 Зөвлөмж..... 15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл 16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Б.ЕРХАНАТ ТАНАА

2022.02.23 № 126

танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.ХУАНГАН

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	**ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН**	**5,898,662.00**	**7,565,662.00**
354	**Хангамжийн материал**	5,898,662.00	7,565,662.00
35410	Бичиг хэргийн материал	44,000.00	44,000.00
35420	Аж ахуйн материал	3,597,700.00	5,264,700.00
35470	Бусад хангамжийн материал	2,256,962.00	2,256,962.00
2	**ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН**	**336,128,061.87**	**378,443,897.27**
39	**ҮНДСЭН ХӨРӨНГӨ**	336,128,061.87	378,443,897.27
392	**Биет хөрөнгө**	314,496,395.19	357,062,230.55
39201	Барилга, байгууламж, орон сууц	277,252,330.00	277,252,330.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(26,824,968.02)	(42,040,292.90)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	96,700,000.00	158,700,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(73,899,999.84)	(84,083,333.15)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	198,104,964.20	218,481,219.20
39206	Хуримтлагдсан элэгдэл	(169,954,120.30)	(181,601,264.37)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	100,799,894.00	101,799,894.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(87,759,204.85)	(91,806,854.23)
39217	Ном	77,500.00	360,532.00
393	**Биет бус хөрөнгө**	21,631,666.68	21,381,666.72
39301	Програм хангамж	1,550,000.00	1,550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(633,333.32)	(883,333.28)
39303	Бусад биет бус хөрөнгө	20,715,000.00	20,715,000.00
3	**НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II**	**342,026,723.87**	**386,009,559.27**
5	**ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН**	**342,026,723.87**	**386,009,559.27**
51	**Засгийн газрын хувь оролцоо**	342,026,723.87	386,009,559.27
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	334,498,880.00	334,498,880.00
51101	Өмч: - төрийн	334,498,880.00	334,498,880.00
512	**Хуримтлагдсан үр дүн**	(225,017,619.77)	(181,034,784.37)
51210	Өмнөх үеийн үр дүн	(225,017,619.77)	(225,017,619.77)
51220	Тайлант үеийн үр дүн	-	43,982,835.40
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	232,545,463.64	232,545,463.64
6	**ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН**	**342,026,723.87**	**386,009,559.27**

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)**	**1,248,245,407.00**	**1,254,267,943.00**
12	**ТАТВАРЫН БУС ОРЛОГО**	**56,973,807.00**	**418,256.00**
120	**Нийтлэг татварын бус орлого**	56,973,807.00	418,256.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	56,973,807.00	418,256.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	56,973,807.00	418,256.00
13	**ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО**	**1,191,271,600.00**	**1,253,849,687.00**
1310	**Улсын төвлөрсөн төсвөөс**	1,191,271,600.00	1,253,849,687.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,191,271,600.00	1,178,428,900.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	-	75,420,787.00
2	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН**	**1,175,139,726.93**	**1,210,285,107.60**
21	**УРСГАЛ ЗАРДАЛ**	**1,175,139,726.93**	**1,210,285,107.60**
210	**БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ**	1,154,471,332.93	1,178,009,327.60
2101	**Цалин хөлс болон нэмэгдэл урамшил**	873,532,838.00	872,001,719.00
210101	Үндсэн цалин	697,730,800.00	699,645,428.00
210102	Нэмэгдэл	128,241,800.00	126,089,201.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	32,164,800.00	30,218,397.00
210104	Урамшуулал	15,395,438.00	16,048,693.00
2102	**Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл**	117,908,500.00	116,839,583.00
210201	Тэтгэврийн даатгал	82,485,300.00	81,693,477.68
210202	Тэтгэмжийн даатгал	8,855,800.00	8,786,526.33
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,084,600.00	7,029,221.14
210204	Ажилгүйдлийн даатгал	1,771,200.00	1,757,305.19
210205	Эрүүл мэндийн даатгал	17,711,600.00	17,573,052.66
2103	**Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал**	42,666,200.00	48,683,200.00
210301	Гэрэл, цахилгаан	2,809,300.00	5,231,501.00
210302	Түлш, халаалт	36,856,900.00	41,014,699.00
210303	Цэвэр, бохир ус	3,000,000.00	2,437,000.00
2104	**Хангамж, бараа материалын зардал**	59,222,230.00	57,252,256.00
210401	Бичиг хэрэг	17,131,160.00	17,745,256.00
210402	Тээвэр, шатахуун	21,137,770.00	20,314,450.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	13,540,400.00	12,980,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	600,000.00	599,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,812,900.00	5,612,550.00
2105	**Норматив зардал**	-	932,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		932,000.00
2106	**Эд хогшил, урсгал засварын зардал**	12,309,000.00	23,479,910.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,166,500.00	8,335,750.00
210604	Урсгал засвар	9,142,500.00	15,144,160.00
2107	**Томилолт, зочны зардал**	10,108,700.00	12,136,400.00

210702	Дотоод албан томилолт	10,108,700.00	12,136,400.00
2108	**Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж**	5,182,898.00	5,340,808.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,641,458.00	3,505,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	336,000.00	336,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,073,900.00	1,073,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	91,540.00	104,508.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	40,000.00	40,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		280,500.00
2109	**Бараа үйлчилгээний бусад зардал**	33,540,966.93	41,343,451.60
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	33,540,966.93	41,343,451.60
213	**УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ**	20,668,394.00	32,275,780.00
2132	**Бусад урсгал шилжүүлэг**	13,000,000.00	13,590,245.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	9,000,000.00	11,590,245.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,000,000.00	2,000,000.00
2133	**Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг**	7,668,394.00	18,685,535.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,668,394.00	18,685,535.00
3	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)**	**73,105,680.07**	**43,982,835.40**
5	**НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)**	**73,105,680.07**	**43,982,835.40**

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	**2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл**	334,498,880.00	232,545,463.64	-298,123,299.84		268,921,043.80
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	**Дахин илэрхийлсэн үлдэгдэл**	334,498,880.00	232,545,463.64	-298,123,299.84	0.00	268,921,043.80
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн			73,105,680.07		73,105,680.07
C08	**2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл**	334,498,880.00	232,545,463.64	-225,017,619.77	0.00	342,026,723.87
D01	**2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл**	334,498,880.00	232,545,463.64	-225,017,619.77	0.00	342,026,723.87
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
D03	**Дахин илэрхийлсэн үлдэгдэл**	334,498,880.00	232,545,463.64	-225,017,619.77	0.00	342,026,723.87
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			43,982,835.40		43,982,835.40
D09	**2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл**	334,498,880.00	232,545,463.64	-181,034,784.37	0.00	386,009,559.27

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)**	**1,191,271,600.00**	**1,178,428,900.00**
13	**ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО**	**1,191,271,600.00**	**1,178,428,900.00**
1310	**Улсын төвлөрсөн төсвөөс**	1,191,271,600.00	1,178,428,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,191,271,600.00	1,178,428,900.00
2	**НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)**	**1,141,393,600.00**	**1,170,190,400.00**
21	**УРСГАЛ ЗАРДАЛ**	**1,141,393,600.00**	**1,170,190,400.00**
210	**БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ**	**1,120,725,206.00**	**1,137,914,620.00**
2101	**Цалин хөлс болон нэмэгдэл урамшил**	873,532,838.00	872,001,719.00
210101	Үндсэн цалин	697,730,800.00	699,645,428.00
210102	Нэмэгдэл	128,241,800.00	126,089,201.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	32,164,800.00	30,218,397.00
210104	Урамшуулал	15,395,438.00	16,048,693.00
2102	**Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл**	117,908,500.00	116,839,583.00
210201	Тэтгэврийн даатгал	82,485,300.00	81,693,477.68
210202	Тэтгэмжийн даатгал	8,855,800.00	8,786,526.33
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,084,600.00	7,029,221.14
210204	Ажилгүйдлийн даатгал	1,771,200.00	1,757,305.19
210205	Эрүүл мэндийн даатгал	17,711,600.00	17,573,052.66
2103	**Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал**	42,666,200.00	48,683,200.00
210301	Гэрэл, цахилгаан	2,809,300.00	5,231,501.00
210302	Түлш, халаалт	36,856,900.00	41,014,699.00
210303	Цэвэр, бохир ус	3,000,000.00	2,437,000.00
2104	**Хангамж, бараа материалын зардал**	57,951,570.00	56,354,000.00
210401	Бичиг хэрэг	16,167,900.00	17,558,000.00
210402	Тээвэр, шатахуун	21,137,770.00	20,314,450.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	13,540,400.00	12,980,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал,	600,000.00	599,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,505,500.00	4,901,550.00
2105	**Нормативт зардал**	800,000.00	800,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	800,000.00
2106	**Эд хогшил, урсгал засварын зардал**	12,574,500.00	25,758,910.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,970,600.00	10,819,250.00
210604	Урсгал засвар	8,603,900.00	14,939,660.00
2107	**Томилолт, зочны зардал**	10,108,700.00	12,136,400.00
210702	Дотоод албан томилолт	10,108,700.00	12,136,400.00
2108	**Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,**	5,182,898.00	5,340,808.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,641,458.00	3,505,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	336,000.00	336,000.00

210803	Даатгалын үйлчилгээ	1,073,900.00	1,073,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	91,540.00	104,508.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	40,000.00	40,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	280,500.00
213	**УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ**	**20,668,394.00**	**32,275,780.00**
2132	**Бусад урсгал шилжүүлэг**	13,000,000.00	13,590,245.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	9,000,000.00	11,590,245.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,000,000.00	2,000,000.00
2133	**Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг**	7,668,394.00	18,685,535.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,668,394.00	18,685,535.00
3	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)**	**49,878,000.00**	**8,238,500.00**
5	**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)**	**49,878,000.00**	**8,238,500.00**
22	**ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ**	**49,878,000.00**	**8,238,500.00**
2200	**Дотоод эх үүсвэрээр**	49,878,000.00	8,238,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	49,878,000.00	8,238,500.00
6	**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)**	**(49,878,000.00)**	**(8,238,500.00)**
8	**НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)**	-	-
9	**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл**		
10	**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл**		

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл**		
2	**НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН**	1,178,428,900.00	1,159,743,365.00
21	**УРСГАЛ ЗАРДАЛ**	1,178,428,900.00	1,159,743,365.00
210	**БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ**	1,161,471,100.00	1,146,153,120.00
2101	**Цалин хөлс болон нэмэгдэл урамшил**	884,541,800.00	872,001,719.00
210101	Үндсэн цалин	708,730,800.00	699,645,428.00
210102	Нэмэгдэл	128,242,300.00	126,089,201.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	32,164,800.00	30,218,397.00
210104	Урамшуулал	15,403,900.00	16,048,693.00
2102	**Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимт**	119,408,800.00	116,839,583.00
210201	Тэтгэврийн даатгал	83,985,600.00	81,693,477.68
210202	Тэтгэмжийн даатгал	8,855,800.00	8,786,526.33
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,084,600.00	7,029,221.14
210204	Ажилгүйдлийн даатгал	1,771,200.00	1,757,305.19
210205	Эрүүл мэндийн даатгал	17,711,600.00	17,573,052.66
2103	**Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал**	48,683,200.00	48,683,200.00
210301	Гэрэл, цахилгаан	4,886,300.00	5,231,501.00
210302	Түлш, халаалт	41,359,900.00	41,014,699.00
210303	Цэвэр, бохир ус	2,437,000.00	2,437,000.00
2104	**Хангамж, бараа материалын зардал**	56,354,400.00	56,354,000.00
210401	Бичиг хэрэг	17,558,000.00	17,558,000.00

210402	Тээвэр, шатахуун	20,316,000.00	20,314,450.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12,980,400.00	12,980,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал	1,100,000.00	599,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,400,000.00	4,901,550.00
2105	**Норматив зардал**	800,000.00	800,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	800,000.00
2106	**Эд хогшил, урсгал засварын зардал**	34,000,000.00	33,997,410.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	18,000,000.00	17,998,750.00
210604	Урсгал засвар	16,000,000.00	15,998,660.00
2107	**Томилолт, зочны зардал**	12,145,700.00	12,136,400.00
210702	Дотоод албан томилолт	12,145,700.00	12,136,400.00
2108	**Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлб**	5,537,200.00	5,340,808.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчи	3,663,500.00	3,505,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	336,000.00	336,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,073,900.00	1,073,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	136,400.00	104,508.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	40,000.00	40,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	280,500.00	280,500.00
210807	Газрын төлбөр	6,900.00	-
213	**УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ**	16,957,800.00	13,590,245.00
2132	**Бусад урсгал шилжүүлэг**	16,957,800.00	13,590,245.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтг	14,957,800.00	11,590,245.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	2,000,000.00
13	**ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР**	1,178,428,900.00	1,159,743,365.00
1310	**УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ**	1,178,428,900.00	1,159,743,365.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,178,428,900.00	1,159,743,365.00
61	**БАЙГУУЛЛАГЫН ТОО**	5.00	5.00
610001	Төсвийн байгууллага	5.00	5.00
62	**АЖИЛЛАГСАДЫН ТОО**	**43.00**	**42.00**
620001	Удирдах ажилтан	5.00	5.00
620002	Гүйцэтгэх ажилтан	33.00	32.00
620003	Үйлчлэх ажилтан	5.00	5.00
65	**ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ**	**43.0**	**42.0**
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	18.00	18.00
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	13.00	12.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	12.00	12.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор У.Ербол гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 31 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл: Шүүн таслах ажил болон шүүн таслах ажлыг хэвийн явуулах нөхцөл байдлыг хангах , Шүүхийн бие даасан байдлыг хангах, шүүхийг хүний нөөцөөр хангах, шүүгчийн хараат бус байдлыг хангах, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, шүүхийн санхүү, эдийн засгийн баталгааг хангах, мэдээллээр хангах чиг үүргийг тухайн шүүхэд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахад оршино.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн Тамгын газрын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын албанаас хяналт шалгалт хийгдэж төсвийн байгууллагын мөнгөн кассын журам, Сангийн сайдын 2017 оны 347 тушаалаар батлагдсан БМ-5 маягтын дагуу агуулахын бүртгэл хөтлөх, жолоочийн тооцооны хуудсыг зөв тооцож баталгаажуулах зэрэг зөвлөмжүүд өгсөн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэль сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1175.1 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 11.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 8.8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн Тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 43.9 сая төгрөгөөр буюу 12.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.00	0.00	0.00
Авлага	0.00	0.00	0.00
Урьдчилгаа	0.00	0.00	0.0
Бараа материал	5898.6	7565.6	1667.0
Үндсэн хөрөнгө	336128.0	378443.9	42315.9
Нийт хөрөнгө	**342026.7**	**386009.6**	**43982.9**
Өр төлбөр	0.00	0	0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	342026.7	386009.6	43982.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	**342026.7**	**386009.6**	**43982.9**

Мөнгөн хөрөнгө, авлагын данс үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 7.5 сая төгрөг болж 1.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Тайлант онд 0.4 сая төгрөгийн бараа материалыг шилжүүлэн авсан ба 61.4 сая төгрөгийн бараа материал худалдан авч, 60.2 сая төгрөгийн бараа материалыг зарцуулжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 378.4 сая төгрөг болж 42.3 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 8.2 сая төгрөгийн хөрөнгийг орлого авч, дээд шатны байгууллагаас 62.0 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, 13.1 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 0.3 сая төгрөгийн номыг шилжүүлэн авсан байна.

Өр төлбөр дансны эхний үлдэгдэл үлдэгдэлгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 386.0 сая төгрөг болж 43.9 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 1254.2 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 6.0 сая төгрөгөөр буюу 0.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө, бараа материал, урсгал санхүүжилт байна.

Нийт зардал өмнөх оноос 35.1 сая төгрөгөөр буюу 3.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалингийн зардал, байр ашиглахтай холбоотой зардал, норматив зардал, эд хогшил, урсгал засварын зардал, томилолт, зочны зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал, бараа үйлчилгээний бусад зардал, урсгал шилжүүлгийн зардлууд байна.

Байр ашиглахтай холбоотой зардал, норматив зардал, томилолт, зочны зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал, бараа үйлчилгээний бусад зардал, урсгал шилжүүлэг өмнөх оноос нэмэгдэж, цалингийн зардал, хангамж, бараа материалын зардал өмнөх оноос буурсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга гараагүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны анх батлагдсан төсөв 1123.4 сая төгрөг, тодотгосон төсөв 1178.4 сая төгрөг байна. Тодотгосон төсөв нь анх баталснаас 55.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд:

Цалингийн зардлыг 11.0 сая, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 1.5 сая, хангамжийн материал 5.2 сая, эд хогшил, урсгал засварын зардал 14.0 сая, томилолт, зочны зардал 2.0 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ, төлбөр хураамжийн зардал 0.3 сая, урсгал шилжүүлгийн зардлыг 14.9 сая төгрөгөөр нэмж баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 1178.4 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр үйл ажиллагаандаа 1159.7 сая төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвийг нийт дүнгээр 18.6 сая төгрөгөөр хэмнэж төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Энэ нь цалингийн зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлын хэмнэлт байна.

Нийт төсвийн 75.2 хувийг цалин, 10.0 хувийг НДШ-ийн зардал, 4.2 хувийг тогтмол зардал, 4.8 хувийг хангамж бараа материалын зардал, 2.9 хувийг эд хогшил, урсгал

засварын зардал, 0.4 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, 1.1 хувийг урсгал шилжүүлэг, 1.4 хувийг бусад зардал тус тус эзэлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвөөр орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайланд холбогдох бүх мэдээллийг толилуулж, тодруулсан байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал гараагүй.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн Тамгын газрын 2021 онд нийт 1178.4 сая төгрөгийн 148 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 1178.4 сая төгрөгийн 137 мэдээллийг хугацаандаа бүрэн байршуулж, 11 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар зохих зөвшөөрөлгүй шилжүүлэн зарцуулсан 7.2 сая, орлого аваагүй бараа материалын 6.3 сая, шагналын зардалд зарцуулсан 2.0 сая, тэтгэвэрт гарсан албан хаагчид дутуу олгосон 1.0 сая төгрөгийн зөрчил, Шилэн дансны хугацаа хоцроосон 5 мэдээлэлд зөвлөмж өгсөн байна. Зөвлөмжийн биелэлтийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан цалингийн зардал, тээвэр шатахууны зардлын зарцуулалтыг шалгах боломжгүй байсан тул гүйцэтгэлийн аудитаар дэлгэрэнгүй шалгах шаардлагатай.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой хугацаа хоцроосон 11 мэдээлэлд зөвлөмж өгөв.

4.1 Залруулсан алдаа

Байхгүй

4.2 Төлбөрийн акт

Байхгүй.

4.3 Албан шаардлага

Байхгүй.

4.4 Зөвлөмж

2.1. Илрүүлэлт: Шилэн дансанд тайлант хугацаанд оруулбал зохих 148 мэдээллээс 11 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

2.2. Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.1.5, 6.1.6 дах заалтуудыг мөрдөж мэдээллийг хугацаанд бүрэн байршуулж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн тамгын газар	1								1	